



Н.Цэдэвсүрэн, доктор /Ph.D/, дэд профессор
Багшийн сургууль, СӨБСС-ийн ахмад багш

МОНГОЛЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН АРГАЗҮЙН ОРЧНЫ ДЭВШИЛТТЭЙ БА СУЛ ТАЛУУД /1921-2009/

Резюме: В первых порах школьного развития среда методики обучения была скудна, поэтому хотя тот факт что учителя начинали формировать свою среду методики обучения самостоятельно, был положительной стороной в процессе развития, но вследствие экономических трудностей это развитие тормозилось и качество учебы учащихся того времени стало отрицательной стороной этого развития. В 1941-1957 годах в школах внедрились некоторые элементы динамические инструменты обучения такие как диапозитивы наглядные пособия, учебные кино материалы, магнитофоны и учителя оборудовали учебные кабинеты имеющие инструменты и оборудования для классных опытов, и тем самым активно начали использовать в обучении различные технические средства.

Начиная с конца 1950-х годов наша государство начали покупать в СССР комплекты школьных наглядных пособий и ими снабжали школы. В связи с вопросами организации 10/11 летних трудовых политехнических школ в 1963-1965 годах по новому разработали и осуществили школьные учебные программы и учебные планы и это формировало основные условия расширения методическую среду в школах. Для осуществления этого решения государство выделило инвестиции и когда работы по снабжению начальных и средних школ наглядными пособиями начали интенсивно развиваться, то и успеваемость учащихся в общеобразовательных школах страны улучшилась и этот факт виден в исторических материалах учреждений нашего образоваия . После 1990-х годов обновления правовой среды образования, организации школы, методической среды содержания шли интенсивно , но реальные результаты относительно вяло шли и отставали

от темпа развития, это доказано социальным опросом и изучением.

Ключевые слова: среда обучения, учебники, инструменты обучения, содержание обучения, программы, учебники, наглядные пособия, стандарты среды обучения

1921-1925 он хүртэл бага дунд сургуулиуд нэгдсэн хөтөлбөргүй, сургуулийн дүрэмд тулгуурлан сургалт явуулж байв. Тэр үед олонх хошуудын танхимууд жинхэнэ сургалт хүмүүжлийн ажлын хэлбэрт ороогүй, багш нарын олонх нь сурган хүмүүжүүлэх ухааны мэргэжил боловсролгүй, сургалтын материаллаг бааз (орчин) муу байсан учир сургалтын үр дүн хангалтгүй, зарим сургууль бичиг үсгийн бүлгэмийн чанартай ажиллаж, зарим нь тарж бутрах байдалд орсон нь шинэ цагийн боловсролын сургалтын орчин бүрдүүлэх туршлага багатай байсантай холбоотой юм. Улмаар 1925 онд багш нарын хоёрдугаар хурлаар бага сургуулийн үндсэн хичээлийн хөтөлбөрийг баталсан, хичээл заах багш нарыг бэлтгэж эхэлсэн нь сургалтын орчныг бүрдүүлэхэд чухал алхам болсон юм.

Хэдийгээр сургалтын орчин хомс байсан ч багш сурагчдын санаачилгаар хичээлд холбогдох зүйлсийг цуглуулж, үзмэрийн булан байгуулж, багш нар гар дээр байгаа материалаар үзүүлэн таниулах хийж эхэлсэн нь сургалтын орчны дэвшилттэй тал боловч энэ ажил жигд биш байлаа. Мөн 1925-1926 онд шинэ цагаан толгой, зарим хичээлийн гарын авлагыг орос хэлнээс орчуулан хөдөөгийн сургуулиудад түгээж байсан нь багш сурагчдыг ном, гарын авлагаар хангах гэсэн ажлын эхлэл юм. Тэр үед хот хөдөөгийн сургуулийн сургалтын орчин эрс тэс ялгаатай байсан нь зарим ахмад сурган хүмүүжүүлэгчдийн дуртгалаас тодорхой байна.

Ч.Дондог(1987:22) “Сурагчид өөрсдөө дан эсгий гудастай нэг дээлээ дэрлэж, нөгөө дээлээрээ хучиж унтана. Хичээл хийхдээ дэр хийдэг дээлээ гудсан дороо хийж, гудсаа 4 нугалан эвхэж дээр нь суун ном дэвтрээ өвдгөн дээрээ тавьж, бичиж уншина” гэснээс үзвэл тэр үеийн хөдөөгийн зарим сургууль ширээгүй байсан нь тодорхой байна. Түүхийн баримт бичгүүд ном зохиолд дурдсанаар сургуулийн хүүхдийн хувцас хоол туйлын муу, дутмаг, гэрийн бүрээс цоорхой, ор байхгүй ариун цэвэр маш муу байжээ. Тэр үеийн сургууль гэрт хичээллэж, нэлээд боломжийн гэгдэх сургууль дэргэдээ гал тогооны гэртэй байлаа. 1937-1938 онд 10, 1938 онд бүх хичээлийн сургалтын агуулгыг шинэчлэн боловсруулсан ч мөн л хөдөөгийн сургуулиуд сургалтын материаллаг бааз муутай байсан юм.

1940 онд сургуулийн насны бүх хүүхдийг бага боловсролтой болгох зорилгыг хэрэгжүүлэхийн тулд сургалтын төлөвлөгөө, хичээлийн программыг шинэчлэн боловсруулсан бөгөөд 1941-1957 онуудад сургалтад, диапозитив үзүүлэн, сүүдэр ший, эгшигт хайрцаг зэрэг сургалтын динамик хэрэглэгдэхүүний элементүүд нэвтэрч, багш нар туршилтын багаж хэрэгслүүд бүхий кабинетийг байгуулж, улмаар сургалтад техник хэрэгсэл эрчимтэй ашиглаж эхэлсэн нь энэ үеийн сургалтын орчны дэвшилттэй тал юм. 1955 онд бүх хүүхдийг нийтээр нь анхан шатны боловсролтой болгох, цаашилбал, 7 жилийн боловсролтой болгохын тулд сургалтын шинэ төлөвлөгөө батлагдаж, хичээлүүдийн кабинетуудын тоо эрчимтэй өсөж, сургалтын үзүүлэн таниулахтай болж эхэлсэн байна. 1950-иад оны сүүлчээс манай улс ЗХУ-аас иж бүрэн үзүүлэн худалдаж авч сургуулиудын кабинетийг² хангаж байлаа.

1963-1965 онуудад хөдөлмөр политехникийн 10/11 жилийн сургууль байгуулах асуудалтай уялдан сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлсэн нь сургалтын орчин өргөжих үндсэн нөхцөлийг бүрдүүлсэн юм. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд улсаас хөрөнгө оруулалт хийж, 10 жилийн үзүүлэн таниулах 30, 8 жилийн сургуулийн үзүүлэн таниулах 74, бага сургуулийн үзүүлэн таниулах 197-г авч тараасан байна. Үзүүлэн таниулахын иж

бүрдэлд сургуулийн төрөл бүрийн суурь машин, радио зангилгааны төхөөрөмж, хичээлийн кино аппарат, үлээвэр хөгжмийн иж бүрдэл, пианино хөгжим зэрэг ордог байв. Сургуулийг үзүүлэн таниулахаар хангах ажил эрчимтэй өрнөсөн энэ үед манай ерөнхий боловсролын сургуулиудын сурлагын амжилт³ дээшилсэн нь боловсролын түүхийн баримт бичгийн судалгаанаас тодорхой байна.

1971-1972 онд сургуулийн бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор сургалтын төлөвлөгөө бүх хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, техник хэрэгслийн кабинетууд байгуулагдан программчилсан сургалтын элемент нэвтэрч, сургалтын орчны эрчимтэй хөгжлийн үе эхэллээ. 1970-аад оны эцэс гэхэд гадаадаас авах үзүүлэнгүүдийн тоо нэмэгдэж, хичээлийн кино аппарат 172, диапроектор 1470, гадаад хэл сургалтын иж бүрэн кабинет 30-ыг гадаадаас авч 8, 10 жилийн 200 гаруй сургуулийг иж бүрэн үзүүлэн таниулахаар хангажээ. Мөн хичээл тус бүрийн үзүүлэн таниулахын нормативыг баталж гаргадаг болсон нь сургуулиудын кабинетийг тохижуулах, орчныг бүрдүүлэх нэг ёсны стандарт, шалгуурын үүргийг гүйцэтгэж байлаа.

1982 оны БНМАУ-ын Ардын боловсролын тухай хуулийг баталсантай холбогдуулан сургалтын агуулгыг 1972 онд боловсруулсан агуулгын зорилго, зарчим логик дэс дарааллыг баримтлан шинэчлэн сайжруулсан байна. Улмаар 1986-1987 онд бага ангийн сургалтын агуулгад хүүхдийг 7 настайгаасургуульд элсүүлэх болсон учир өөрчлөлт хийжээ. Энэ агуулгыг хэрэгжүүлэхийн тулд хүүхдийг 7 наснаас нь сургах сургалтын шинэ системд бүрэн шилжих хүртэл мөрдөх хөтөлбөр, сурах бичиг боловсруулан гаргасан юм. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зөвлөмж, дидактик материал үзүүлэн таниулах, ажлын дэвтэр зэрэг заах арга зүйн иж бүрэн материал хэвлүүлсэн нь 7 настай хүүхдийн сургалтын орчин бүрдүүлэх суурь хөрс нь болжээ. Энэ үед “Сургуулийн системийг боловсронгуй болгох тухай МАХН-ын Төв Хорооны сэдэв”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сурагчдыг амьдрал хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр мэргэжлийн сургалт явуулах, хичээлийн практик өгөөжийг дээшлүүлж, практик лабораторын ажлыг заавал

2 Иж бүрэн үзүүлэнг нэг жилд 40 орчмыг захиалан авч бүгд 1300-г авсан гэсэн баримт бий. Мөн 1960 онд АБЯ-ны гадаад захиалгад биологи, физик, хими, газарзүй, зураг, шугам зургийн кабинетуудыг иж бүрнээр, сургалтын кино 82 нэр төрлийг захиалж байв./УТА Ф-6-4-111/

3 Энэ үед манай орны сургуулиудад 191962 сурагч хичээллэж, 1968-1969 оны хичээлийн жилийн эцсээр 191309 сурагч дүгнэгдэж, 23443 нь онц, 51561 нь сайн, 104005 нь дунд, 12300 сул дүнтэй суралцаж, сурлагын амжилт 93,5% чанар нь 39% байсан байна. /УТА, Ф-6-4-149/

хийлгэх талаар зорилт тавьж ажилласан нь сургалтын кабинетуудын тоног төхөөрөмжийг сайжруулах чухал алхам юм. Мөн мэргэжлийн баримжаа олгох сургалтыг бааз үйлдвэр, аж ахуйн газруудад зохион явуулах, хүүхдэд хөдөлмөрийн болон мэргэжлийн бэлтгэл олгох ажлыг инженер техникийн ажилтнууд удирдаж байсан нь сургалтын орчныг зөвхөн сургуулийн анги танхимаар хязгаарлах биш, үйлдвэрийн газрууд сургалтын бааз болж, сургалтын орчин өргөжин хүрээгээ тэлсэн бас нэгэн дэвшилттэй тал болно. Гэвч хичээлийг нэг загвар хэлбэрээр явуулах, хичээл дээрх сурагчдын бие даасан бүтээлч ажиллагааг ганц нэг асуултад хариу авах төдийгөөр хязгаарлах, сурагчдаар шинжилгээ судалгааны ажил хийлгэхийн оронд, багш өөрөө тайлбарлан ярих, зөвхөн самбар шохой хэрэглэн хичээл явуулах дутагдалтай тал бүрмөсөн арилаагүй байлаа. 1980-1990 оны хооронд сургалт хүмүүжлийн ажлын чанарыг сайжруулах, сурагчдыг амьдрал хөдөлмөрт бэлтгэх талаар эцэг эх, олон нийт, үйлдвэр албан газар, байгууллагын туслалцаа дэмжлэгийг бодитой авч ирсэн сайн тал бий. Хамтын энэ хүчин чармайлтаар сургалтын нэгдмэл орчныг бүрдүүлэхэд сургууль багш нар санаачилгатай ажилласны үр дүн нь сурагчдын сурлагын амжилтад тодорхой нөлөө үзүүлж байсан нь архивын баримтаас⁴ тодорхой байдаг.

1990 онд манай улс зах зээлийн харилцаанд шилжиж, мөнгө санхүүгийн хомсдол үүссэн учир сургалтын орчинд дутагдал, бэрхшээл учирч сургалтын хэрэглэгдэхүүн хуучирсан сул талтай. Гэсэн хэдий ч боловсролын хөрөнгө оруулалтын нийт зардалд сургалтын тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулах зардал 1998 онд 12,3 хувийг эзэлж байсан бол 2003 онд 64,7% болсон байна. Үүний үр дүнд ерөнхий боловсролын сургуулиудад өнгөрсөн хугацаанд сурагчийн ширээ сандал, багшийн ширээ ангийн самбар, компьютер, байгалийн ухааны лабораториудыг нийлүүлжээ. Тухайлбал, БСХХ-1 хүрээнд 1998 онд 148 сургуульд физик, хими, биологийн 444 лаборатор, нийт 692 сургуульд 3340 компьютер нийлүүлсэн байна. МХТ-ийн хэрэгслийг сургалтад ашиглах идэвх чармайлт багш нарын дунд өрнөж, сургалтын орчин боловсронгуй болох эхлэл тавигдаж байвч тэдний арга туршлага дутах, уг хэрэгслүүдийн

хангамж хүрэлцээ тааруухан байгаа юм.

Монголын ерөнхий боловсролын сургалтын орчин өөрийн орны өвөрмөц онцлогтой уялдан 90 орчим жил хөгжиж ирсэн боловч сургалтын агуулгын өөрчлөлтийн шат бүхэн орчноо эрчимтэй шинэчилж чадаагүй, сургалтын орчин бүтээлч биш, удаан өөрчлөгдөж байсан зэрэг сул талууд бий. Жишээлбэл: Сургалтын иж бүрэн хэрэглэгдэхүүнийг гадаад улсаас их хэмжээгээр худалдан авч байсан нь багш нарыг бэлэнчлэх сэтгэлгээнд сургаж, багш сурагчдын хамтын бүтээлч ажиллагаа өрнөх орчныг хааж, гадаадыг бишрэн шүтэхэд хүргэж байлаа.

Шилжилтийн үеийн нийгэмд боловсролын байгууллага эдийн засгийн хувьд хямарч, суралцагчдын ахуй амьдралын нөхцөл сургалтын орчинд бэрхшээл учирч, сургуулиуд материаллаг баазын хувьд сайнгүй байлаа. Энэ үед гадаад орноос манай сургалтын системийг судалсан судлаачдын⁵ бүтээлд сургалтын хэрэглэгдэхүүний хангамж дутуу, сургалтын орчинд хомсдол байгааг шүүмжилсэн тохиолдол цөөнгүй бий.

Мөн зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн, өмчийн хэлбэр өөрчлөгдсөн үеэс эхлэн монголын хөдөө нутаг эзгүйрч, хот чиглэсэн их нүүдлийн уршгаар нийслэл хотод хүн амын хэт төвлөрөл бий боллоо. Үүнээс үүдээд сургууль цэцэрлэгийн суудлын тоо, хүчин чадал хүрэлцэхгүй болж, нэг анги, бүлэгт суралцах хүүхдийн тоо өссөн нь сургалтын технологийн шинэчлэл болон багш нарын ажлын чанарт бэрхшээл учруулж байгаа нь сургалтын орчны бас нэг сул тал юм. Жишээлбэл: Улаанбаатар хотод 2008-2009 оны хичээлийн жилд төрийн өмчийн 104 сургуульд 185016 сурагч суралцаж, 8821 багш ажиллаж, 3458 бүлгийн 100199 сурагч 1-р ээлжинд, 2466 бүлгийн 81705 сурагч 2-р ээлжинд, 89 бүлгийн 3114 сурагч 3-р ээлжинд хичээллэжээ.

5 “Тоног төхөөрөмж зайлигүй хэрэгтэй болохыг дурьдах явдал нь тэнгэ асуудал болов уу. Үүнийг дурдсан шалтгаан гэвэл үнэн хэрэгтээ Монголын сургуулийг бүх бусад байдал энэ асуудалтай холбоотой. Багшлах эрмэлзэл хүслийг төрүүлэх өөр нэг тал нь багшлах нөхцөлийг өөрчлөх явдал билээ. Ангиа чимэх, багш нар өөрсдийгөө хичээлд бэлдэх боломж олгох. Бүр наад захын ном, цаас, сургалтын материал үзүүлэн таниулах хийх зэрэг зүйлс яаралтай хэрэгтэй байна.” 71 Пьер Шульц, Ёон Нилсэн, Кизэстэн Айлгрин “12 настай монгол хүүхдүүдийн сурах чадавх” УБ., 1997/.

4 “1985-1986 оны хичээлийн жилд улсын хэмжээгээр 406225 сурагч шалгагдсаны 38765 нь онц, 106478 нь сайн, 255598 нь дунд, 5384 нь сул дүнтэй гарч, 98,6%-ийн амжилт, 36,0%-ийн чанарын үзүүлэлттэй байлаа” (УТА Ф-4-114)

Хүснэгт - 1 2008-2009 оны хичээлийн ачааллын судалгаа:

Дүүргүүд	Сурагчдын тоо	Анги дүүргэлтийн дундаж	Ерөнхий шалгалтын дундаж оноо	Сургалтын амжилтын өсөлт	Сургуулийн ачаалал
Хан-Уул	14909	31.1	476.7	1.7	2,2
Баянгол	27533	32.7	496.0	1.8	2,1
Багануур	5808	28.7	490.0	- 05	2,0
Сүхбаатар	18160	33.4	518.0	2.4	2,1
Чингэлтэй	20042	35.6	518.9	2.2	2,2
Сонгинохайрхан	33144	34.6	479.0	1.1	2,3
Багахангай	594	25.8	466	-2.6	1,9
Баянзүрх	34825	34.6	508.3	1.2	2,3
Налайх	5253	32.0	502.3	1.0	2,2

Манай бага дунд боловсролын систем сургалтын үзэл баримтлал, бодлого чиглэлээрээ дэлхийн түвшинд хүрсэн ч сургалтын дотоод орчин хоцрогдож байгаа нь аль ч судалгаанаас тодорхой байна. Сургуулийн бүтэц, хэв шинж агуулга аргазүйн шинэчлэлийн бодит үр дүн харьцангуй удаан үргэлжилж, хөгжлийн хурдцаас хоцорч буй шалтгаан нь сургалтын орчны хөгжлийн сул талтай холбоотой.

Стандартад суурилсан боловсролын системийг хэрэгжүүлэх асуудлын хамгийн чухал үе шат болох ЕБС-ийн суралцагчдад бага дунд боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөлийг оновчтой тодорхойлох нь чухал. Сургалтын орчинд тавигдах наад захын шаардлагыг нягтлан боловсруулахын ач холбогдол нь:

- Ерөнхий дунд боловсролын стандарт ёсоор суралцагчид зайлшгүй төлөвшсөн байх цогц чадамж, чадвар үнэт зүйлийн системийг эзэмших нөхцөлийг тодорхойлох;
- Сургалтын материалаг болон үйлийн орчинд тавигдах наад захын шаардлагыг судалгааны үндсэн дээр тогтоож, түүнийг сургуулийн амьдралд хэрэгжүүлснээр суралцах таатай нөхцөлийг зохион байгуулах боломж бүрдэх.

Боловсролын шатлал бүхэнд агуулгын, орчны, үнэлгээний стандартууд нь сургалтын үйл явцыг бүхэлд нь тодорхойлж байдаг. Тухайлбал, сургалтын үйл явцыг системийн хандлагаар авч үзэх тохиолдолд оролтоос гаралт хүрэх хувиргалтын хүрээ, буюу сургалтын агуулгыг, агуулгын стандарт, хувиргалт буюу процессын эрчимжилтийн нөхцөлийг орчны стандарт,

гаралтын шалгуурыг үнэлгээний стандарт тус тус тодорхойлно.

Иймд сургалтын орчинд үнэлгээ өгөхийн тулд стандарт (сургалтын орчинд тавигдах шаардлага) зайлшгүй хэрэгтэй байна.

ДҮГНЭЛТ

Дэлхий нийтийн боловсролын хөгжлийн чиг хандлагыг баримталж, сургалтын агуулга технологийг тасралтгүй хөгжүүлэх үе шат бүхэнд сургалтын орчны системийн бүрэлдүүлбэрүүд шинэчлэгдэж байдаг зүй тогтолтой болохыг судалгааны үр дүн батлав. 1920-иод оны сүүлчээр сургуулийг сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах арга хэмжээ авч байсан боловч тэр үеийн улс төр эдийн засгийн тогтворгүй байдлаас болж сургалтын орчин бүрэлдэх үйл явц удааширсан нь сургалтын чанарт сөрөг нөлөө үзүүлж байсныг судалгаа нотлов. 1921-1940 онуудад Монголын сургалтын агуулгыг удаа дараа шинэчилж байсан боловч энэ үеийн сургалтын орчин уламжлалт сургалтын орчны шинжийг өөртөө агуулсан төдийгүй, европ маягийн сургалтын орчны эхлэл тавигдсан ч хурдацтай хөгжиж чадаагүй байна.

1941-1957 онуудад сургалтад, диапозитив үзүүлэн, сүүдэрший, эгшигт хайрцаг зэрэг сургалтын динамик хэрэглэгдэхүүний элементүүд нэвтэрч, туршилтын багаж хэрэгслүүд бүхий кабинетууд байгуулагдаж эхэлсэн болохыг энэхүү судалгаа нотлов.

1958-1986 оны үед хичээлүүдийн кабинетууд иж бүрэн үзүүлэн таниулахтай болж, техник хэрэгслийн кабинетууд байгуулагдан

программчилсан сургалтын элемент нэвтэрч, сургалтын орчны эрчимтэй хөгжлийн үе эхэлсэн хэдий ч үзүүлэн таниулах материалыг гаднаас ихээр авсан нь багш нарыг бэлэнчлэх сэтгэлгээнд сургасан муу үр дагавартай болсон нь тодорхой.

1990-ээд оноос хойш боловсролын эрхэм зорилго боловсролын эрх зүй, сургуулийн бүтэц хэв шинж, агуулга, арга зүйн шинэчлэл эрчимтэй хийж байвч уг шинэчлэлийн бодит үр дүн харьцангуй удаан үргэлжилж, хөгжлийн хурдцаас хоцорч байгаа судалгаа нотолж байна. Багш нар дээрх шинэ бодлого зорилтыг хуучин орчинд хуучин сэтгэлгээ арга барилаар хэрэгжүүлэх гэж олон жил ажиллаж, хот руу чиглэсэн их нүүдлийн уршгаар сургуулийн суудлын тоо, суралцаж буй сурагчдын тооноос зарим тохиолдолд 2 ба түүнээс илүүгээр бага байгаа нь шинэчлэлийг бодит үр дүнг бууруулж байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Бандий, Р. (1995). “Боловсролын маркетинг”
”Боловсрол судлал, ¹1
- Батсуурь, Ц., Жадамба, Б. (2005) “Боловсролын хөгжлийн онол үзэл баримтлалын чиг хандлага” МУБИС-ийн “Лавай”
Боловсролын онол арга зүйн сэтгүүл.
Улаанбаатар
- Батхуяг, С. (2001). “Сурган хүмүүжүүлэх сэтгэлгээнд шинэчлэл хийхийн учир”
Монголын боловсрол судлаач эрдэмтдийн сонгомол өгүүллийн түүвэр” 20-р зуун.
Улаанбаатар
- Боловсролын салбарын 2006-2007, 2007-2008 оны хичээлийн жилийн статистик мэдээллийн эмхэтгэл
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан яам. (2003-2008). *Мэдээлэл- лавлах*. Улаанбаатар
- (1927). БНМАУ-ын дунд сургуулийн танхимын дүрэм хэмжээ” Монгол улсын 17-р он, 3-р сарын 25-ны өдрийн засгийн газрын 11-р тогтоол/
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам. (1984). “Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн үзүүлэн таниулах, сургалтын тоног төхөөрөмжийн үлгэрчилсэн жагсаалт”. Улаанбаатар
- Монгол Улсын Засгийн Газар. (1992, 1996, 2002). Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр. Улаанбаатар
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан яам. Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх

мастер төлөвлөгөө

- Боловсрол, соёл, шинжлэх ухаан яам (2006). Монгол улсын бага дунд боловсролын салбарт 2015 он хүртлэх хугацаанд Мэдээлэл холбооны технологийг нэвтрүүлэх үндсэн чиглэл. Улаанбаатар
- Монгол Улсын Их хурал. (2002). Монгол улсын боловсролын тухай хуулиуд. Улаанбаатар
- (2008). Монгол Улсын үндсэн хууль” УБ., 11-рх.
- Сүхбаатар, Б., Ганчимэг, Г. (2006). “Хөдөлгөөнт холбооны хэрэгсэлд суурилсан сургалтын тухай” (Мэдээлэл харилцааны технологийг сургалтад хэрэглэх нь). Улаанбаатар
- Цанжид, А., Лхагважав, Ч., Дамдинсүрэн, Б. (2001). “Монголын ерөнхий боловсролын хөгжлийн стратеги” Чанартай боловсрол хөгжлийн баталгаа- Багш нарын бага хурал. Улаанбаатар
- Чимэдлхам, Ц. (2005). “Боловсролын салбарт мэдээлэл холбооны технологийг нэвтрүүлж, хөгжүүлэх онол арга зүйн асуудалд “ Боловсрол судлал,¹3 . Улаанбаатар